



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 0/495

Есөнбулаг

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай" 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн бие засах байгууламж барих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг сумдын Засаг дарга нарт шилжүүлсүгэй.

2.Төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн дотор бэлэн болгож, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр ил тод, шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж, шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ